

Тэгш хамран сургах боловсролын хэлтэс  
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШ Ү
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ									
1.1.	Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	-	-	-	-	-	Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах зорилтыг бүрэн хангаж, ажилласан.	100%	100%
1.1.1	Суралцагчийн ялгаатай хэрэгцээг хангах сургалтын орчин, тохирох	Батлагдсан төсөв, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт	Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, тоног төхөөрөмжийг	-	Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулсан	Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, цэцэрлэг,	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд бүх түвшний боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор	100%	100%

<p>хэрэглэгдэхүүнийг үе шаттай нэмэгдүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.</p>			<p>хүлээлгэн өгсөн байна.</p>		<p>байна.</p>	<p>сургуульд холбогдох хэрэглэгдэхүүнийг нийлүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмших хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.</p>	<p>“Боловсролын Түншлэл” олон улсын байгууллагын тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” EQUAL төслийн хүрээнд виртуал дохионы хэлмэрч платформыг хөгжүүлж, монгол дохионы хэлний хөрвүүлэх технологийн шийдлийг боловсролын үйлчилгээнд нэвтрүүлэн ердийн ерөнхий боловсролын сургуульд сонсголын бэрхшээлтэй хүүхэд элсэн суралцах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж, виртуал дохионы хэлмэрч платформыг хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулан “Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн хэл болох монгол дохионы хэлний хөрвүүлэх технологийн шийдлийг боловсролын үйлчилгээнд нэвтрүүлэх” тендэрийн баримт бичгийг 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр худалдан авах ажиллагааны цахим системд нээлттэй байршуулж, 2024.11.19-ний өдөр тендэрийг нээж, үнэлэв. Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд 2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг БШУ-ны сайдын А/467 дугаар</p>		
---	--	--	-------------------------------	--	---------------	--	--	--	--

							<p>тушаалаар батлан хэрэгжүүлээ. ЕБ-ын 63 дугаар сургуулийн өргөтгөл барих газар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сувиллын цэцэрлэг байгуулах газар, 29, 116-р дугаар сургуулийн газрын маргаан, 70,116-р сургуулийн дотоод сүлжээний асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. 29-р сургуульд сандал, ширээ /130 сая₮/, 55, 116-р сургуулиудад лифт /400 сая₮/, 270,07 сая төгрөгийн сургалтын тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, 55, 63, 70 дугаар сургуульд сурагчдын автобус авах 690,0 төгрөгийн төсвийгСХОГ, БЕГ-тай хамтран тус тус олгов. Боловсролын салбарын цахим шилжилтийн хүрээнд EDU TECH нэгдсэн арга хэмжээг 2024 оны 05-р сард зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчид төрийн үйлчилгээг хүртээмжтэй авах e-hurteemj цахим платформ хөгжүүлэлтийн нээлтийг зохион байгуулж, нийт 300 хүн оролцов.</p> <p>Хавсралт: 7 файл</p>		
1.1.2	Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн боловсролд хамрагдалтын	50,0	Судалгааны тайлан - авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	Судалгааны удирдамж боловсруулж, судалгааны ажлыг	Хилийн застав, асрамж халамжийн төвд амьдарч	БШУСайдын 2024 оны А/186 дугаар тушаалаар "Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн ерөнхий боловсролд хамрагдалтын нөхцөл байдлыг	100%	100%

	<p>нөхцөл байдалд тандан судалгаа хийж, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах арга хэмжээг удирдлага зохицуулалта ар хангана.</p>				<p>эхлүүлсэн байна.</p>	<p>буй хүүхэд, эрх нь хязгаарлагдсан хүүхэд, сүм хийдэд шавилан сууж буй хүүхдийн боловсролд хамрагдалтын нөхцөл байдалд тандан судалгаа хийсэн байна.</p>	<p>тандан судлах" судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. судалгааны маягтыг БСҮХ боловсруулж, БСҮХ-ийн захирлын 2024 оны 2 сарын 27-ны өдрийн 44 дүгээр албан бичгээр ирүүлсэн. Судалгаа хийх баг, судлаачдыг сонгох уулзалтыг 2 удаа зохион байгуулж, Хүний эрхийн судалгаа мэдээллийн хүрээлэн ТББ, Ядгаатай өнцөг ТББ, болон судлаачидтай хамтран ажиллаж, Хилийн застав, асрамж халамжийн төвд амьдарч буй хүүхэд, эрх нь хязгаарлагдсан хүүхэд, сүм хийдэд шавилан сууж буй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн талаарх судалгааг хийв. Судлагаа хийх тухай ТНБД-ын 2024 оны 06 сарын 2/2608, 2/2609, 2/2771 дугаар албан бичгийг Хил хамгаалах ерөнхий газар, ШШГЕГ, ХХХЕГ-т хүргүүлж, холбогдох стаистик мэдээллийг авч хамтарч ажиллалаа. Дээрх зорилтот бүлгийн хүүхдүүдийн нөхцөл байдал, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар бодлогын зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү судалгааг хийлээ. Судалгаанд аймаг, нийслэлд үйл ажиллагаа</p>		
--	--	--	--	--	-------------------------	--	---	--	--

							<p>явуулж буй 21 асрамж халамжийн төвийн хүүхдүүд, багш, НА, сэтгэлзүйчид, Ерөнхий боловсролын 110 дугаар дунд сургуулийн багш, НА, сэтгэлзүйч,, 112 дугаар сургуулийн багш, хүүхдүүд болон Өвөрхангай, Хөвсгөл, Налайх, Улаанбаатар хот дахь гандан хийдийн удирдлага, шавилан сууж буй хүүхдүүд, тэдний эцэг эхийн төлөөлөл, ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны албан хаагчид, хамрагдлаа. Судалгааны дүгнэлтийг үндэслэн зөвлөмж боловсруулж ажиллав. Сайдын 2024 оны А/202 дугаар тушаалаар Тэгш хамран сургах боловсролыг дэмжих, сургалт нөлөөллийн ажлын төлөвлөгөөг батлуулж, энэ хүрээнд ГСТ-г хэрэгжүүлэх арга зүйн сургалтад асрамж халамжийн төвийн 40 багшийг хамруулав. Асрамж халамжийн төвд судалгаагаар 78 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд амьдарч байгаа ч 8 нь боловсролын гадна байна. Судалгаанд хамрагдсан багш нар ГСТ-ний талаар ойлголтгүй байсан.</p> <p>Хавсралт: 9 файл</p>		
1.1.3	Цэцэрлэг, сургуулийн багш нарыг ялгаатай	Батлагдсан төсөв, хөтөлбөр	Сургалтад хамрагдсан багшийн тоо	-	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн	Сайдын 2024 оны "Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, зардал батлах тухай" А/94 дүгээр тушаалыг батлуулж,	100%	100%

<p>хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад үе шаттай хамруулах ажлыг удирдлага, зохицуулалта ар хангах.</p>	<p>ийн санхүүжилт</p>				<p>150 багшийг ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулсан байна.</p>	<p>150 багшийг ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулсан байна. 500 багшийг ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулсан байна. Тэгш хамран сургах боловсролын багш нарын мэргэжлийн хөгжлийн бүлэг байгуулагдсан байна.</p>	<p>“Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн нэгдүгээр бүрэлдэхүүнд хамрагдаж буй зорилтот Архангай, Сэлэнгэ, Увс, Сүхбаатар аймгийн болон нийслэлийн СБД, ХУД-ийн 18 ЕБС-ийн дунд ангийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 187 эцэг, эхчүүдэд “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд үнэлгээ хийхэд оролцох чиглэлээр эцэг эхчүүдийн чадавхыг бэхжүүлэх” сургалт, 8307 сурагчид “Хөгжлийн бэрхшээлтэй үе тэнгийн найзуудаа дэмжих чиглэлээр нийт суралцагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх” нөлөөллийн арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сард зохион байгуулсан. /68,551,150 ₮/ Сайдын 2024 оны Сургалт зохион байгуулах, зардал батлах тухай А/93 дугаар тушаалыг батлуулж, тус зорилтот ЕБС-ийн дунд ангийн 2600 багшид “Тэгш хамран сургах боловсролын сургалтын хөтөлбөр, арга зүй, сургалтын орчинд тохируулга хийх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, суралцагчийг үнэлэх арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. /286,144,312 ₮/ Мөн төслийн хүрээнд Боловсролын сайдын А/60</p>		
---	-----------------------	--	--	--	---	---	--	--	--

						<p>дугаар тушаалар “Багш, тусгай хэрэгцээт боловсрол” мэргэжлээр хөрвөх сургалтад 18 багшийг МУБИС-д суралцуулж байна. “Монгол дохионы хэлний анхан шатны мэдлэг, чадвар олгох” сургалтыг Боловсролын сайдын "Сургалт зохион байгуулах, зардал батлах тухай" А/86 дугаар тушаалаар, удирдамж, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, батламж гардуулсан. Жайка ОУБ-тай хамтран Старт-2 төслийн хүрээнд ХБХ-тэй ажиллаж буй орон нутгийн багш нарт сургалт зохион байгуулж, зөвлөн тусалсан. 55, 63-р сургуулийн 16 багшийг 2024.03.25-31-ний өдрүүдэд БНТУ-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулж, олон улсын туршлага судлуулсан. АХБ-ны санхүүжилтээр Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд суралцахуйн түгээмэл загварыг ашиглах нь сургалтад аймаг, нийслэлийн 200 багшийг хамруулсан.</p> <p>Хавсралт: 8 файл</p>		
1.2.	Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид	-	-	-	-	<p>Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох ажлыг</p>	100%	100%

	суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох ажлыг удирдлага зохицуулалтаар хангах						удирдлага зохицуулалтаар хангах зорилтыг бүрэн хэрэгжүүлж ажилласан.		
1.2.1	Тусгай хэрэгцээт суралцагчид элсэлтийн ерөнхий шалгалт өгөх тохируулга хийх ажлыг удирдлага зохицуулалтаар хангах	-	Элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	-	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид элсэлтийн ерөнхий шалгалт өгөх тохируулга хийгдсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид элсэлтийн ерөнхий шалгалт өгөх тохируулга хийгдсэн байна.	Боловсролын үнэлгээний төв нь хөгжлийн бэрхшээлтэй шалгуулагч элсэлтийн ерөнхий шалгалтад бүртгэгдсэн тохиолдолд шалгалтын үед шаардлагатай тохируулгын талаарх мэдээллийг шалгуулагчаас урьдчилан авч элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөд зориулсан тусгай өрөө бэлтгэх, шалгалтын цагийг уртасгах, шалгалтын даалгаварт тохируулга хийх, туслах багш ажиллуулах зэрэг дэмжлэг үзүүлдэг. Үүнтэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн элсэлтийн ерөнхий шалгалт өгөх тоо нэмэгдэж байна. 2020 онд 13 шалгуулагч бүртгүүлж 12, 2021 онд 22 шалгуулагч бүртгүүлж 20, 2022 онд 31 шалгуулагч бүртгүүлж 31, 2023 онд 33 шалгуулагч бүртгүүлж 29 хөгжлийн бэрхшээлтэй шалгуулагч элсэлтийн ерөнхий	100%	100%



							шалгалтад хамрагдсан. 2023-2024 оны элсэлтийн ерөнхий шалгалтад оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд холбогдох тохируулгууд бүрэн хийгдэж, 100% хамрагдсан. Боловсролын сайдын 2024 оны А/202 дугаар тушаалаар Тэгш хамран сургах боловсролыг дэмжих, сургалт нөлөөллийн ажлын төлөвлөгөөнд 26 ажлыг тусган батлуулж, төлөвлөгөөний 11-т "Их дээд, сургуулийн элсэлтийн шалгалт, олимпиад уралдаан тэмцээн болон гүйцэтгэлийн үнэлгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулах тохируулгын талаар олон нийтэд мэдээлэл хүргэх" ажлыг тусгаж, 2024 оны өвлийн элсэлтийн шалгалттай холбоотойгоор ЭЕШ-д оролцох ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд зориулж хэрхэн тохируулга хийдэг тухай мэдээллийг БҮТ-тэй хамтран олон нийтэд мэдээлэл хүргэсэн.  Хавсралт: 1 файл		
1.2.2	Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн	-	Шинэчлэн боловсруулсан үнэлгээний аргачлал	Үнэлгээний аргачлал	Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн	болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гүйцэтгэлийн	Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээ, багш нарын үнэлгээний аргачлалыг шинэчлэн боловсруулах ажлыг удирдлагаар хангах, багшийн гүйцэтгэлийн үнэлгээний арга	100%	100%

	гүйцэтгэлийн үнэлгээ, багш нарын үнэлгээний аргачлалыг шинэчлэн боловсруулах ажлыг удирдлагаар хангах				гүйцэтгэлийн үнэлгээ, багш нарын үнэлгээний аргачлалыг шинэчлэх санал боловсруулах	үнэлгээ, багш нарын үнэлгээний аргачлалыг шинэчлэн боловсруулсан байна.	зүйд тохируулга хийх санал боловсруулж ажиллалаа. СӨБ, ЕБС, МБТБ-ын багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний журмыг шинэчлэх ажлын хүрээнд тусгай сургууль, цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний аргачлалын санал боловсруулж тусгав.  Хавсралт: 2 файл		
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
3.3.	Тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлэх богино хугацааны төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрхзүйн баримт бичгийг боловсруулах, удирдлага зохицуулалтаар хангах	-	-	-	-		Тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлэх богино хугацааны төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрхзүйн баримт бичгийг боловсруулах, удирдлага зохицуулалтаар хангах зорилтыг бүрэн хангаж ажилласан.	100%	100%

3.3. 1	Тусгай хэрэгцээт боловсролын багшийг хөрвөх сургалтаар бэлтгэх ажлыг удирдлага зохицуулалтаар хангах.	-	Багшийн гурван тулгуурт хөгжлийн бодлого	МУБИС-ийн багш, тусгай хэрэгцээт боловсрол хөтөлбөр	-	Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх хөрвөх сургалтыг эхлүүлсэн байна.	Боловсролын сайдын 2024 оны А/118 дугаар тушаалаар Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” (EQUAL) төслийн “Тэгш хамран сургах боловсрол” бүрэлдэхүүний хүрээнд Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, МУБИС болон төслийн баг хамтран тэгш хамран сургах боловсролын чиглэлээр баримталж буй бодлого шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилтийг танилцуулах, тусгай хэрэгцээт боловсролын талаар олон нийтэд таниулах арга хэмжээг зохион байгуулсан. МУБИС-ийн Боловсрол судлалын сургуультай хамтран "багш, тусгай хэрэгцээт боловсрол"-ын хөтөлбөрт тохируулга хийж, багш мэргэжлээр төгссөн хүнийг 1 жилийн хугацаанд хөрвөх сургалтаар тусгай хэрэгцээт боловсролын багшаар бэлтгэх зохицуулалтыг бий болгож, сургалтыг цахим болон танхим хосолсон байдлаар зохион байгуулах бэлтгэл ажлыг хангав. Сургалтын 90,0 гаруй сая төгрөгний тэтгэлгийг Улаанбаатар хот, орон нутгийн ерөнхий боловсролын 18 сургуулиас тус бүр 1 буюу нийт	100%	100%
-----------	---	---	--	---	---	---	--	------	------

							18 багшид олгон, Монгол Улсын Боловсролын Их Сургуульд “Багш, тусгай хэрэгцээт боловсрол” мэргэжлээр 1 жилийн хөрвөх сургалтад хамруулж байгаа юм. Мөн МУБИС-ийн “Багш, тусгай хэрэгцээт боловсрол” мэргэжлийн хөрвүүлэх сургалтад хамрагдах Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт тэтгэлэгт хөтөлбөрийн батламжийг гардуулж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан.  Хавсралт: 5 файл		
3.3.2	Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх дэмжих төвийн бүтэц орон тоо, үйл ажиллагааны дүрмийн төсөл боловсруулж, батлуулна.	-	Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаал	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх аргачлал	Дүрмийн төслийг боловсруулж, хэлэлцүүлнэ.	Дүрмийг батлуулсан байна.	Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр А/60 дугаар тушаалаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх дэмжих төвийн үйл ажиллагааны дүрэм"-ийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, холбогдох цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоотой байгуулсан. Тус ажлын хэсэг байгуулагдсанаас	90%	90%

						<p>хойш хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээнд цогц байдлаар хамрагдах орчин, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр талуудтай зөвлөлдөн, дүрмийн төслийг боловсруулж, хэлэлцүүлэн ажиллаж байна. 2024 оны 03 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд салбарын яамдуудын холбогдох албан хаагчид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд дэмжих үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцсан. Мөн дүрмийн төслийг 04 дүгээр сарын 17, 05 дугаар сарын 08, 15-нд тус тус хэлэлцүүлж, салбар дундын уялдаа бүхий цогц дэмжлэгийг хүүхдэд нэг дор үзүүлэхэд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх, холбогдох зохицуулалтыг хангах чиглэлээр Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамны хамтарсан уулзалтыг 2024 оны 05 дугаар сарын 02, 08 дугаар сарын 15-ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулж, ажлын хэсгийн хэлэлцүүлгийг 2024.09.10, 11.12-ны өдрүүдэд өргөтгөсөн байдлаар зохион байгуулж, Боловсролын сайдын 2024 оны</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							1/1902 дугаартай албан бичгээр ГБХНХЯ, ЭМЯ-наас санал авч тусган эцэслэн төлөвлөж, тусган Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар системд оруулсан. Хавсралт: 4 файл		
3.3.3	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид ганцаарчилсан сургалт зохион байгуулах журам, сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалыг боловсруулж, батлуулна.	-	Сайдын тушаал	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/155 дугаар тушаал Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/206	Журам, аргачлалын төслийг боловсруулж, хэлэлцүүлсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид ганцаарчилсан сургалт зохион байгуулах журам, сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал батлагдсан байна.	Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн "Журам батлах тухай" А/81 дүгээр тушаалаар "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид ганцаарчилсан сургалт зохион байгуулах журам", "Ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид ганцаарчилсан сургалт зохион байгуулах журам"-ыг тус тус батлуулж, Боловсролын сайдын 2024 оны 1/1004 дугаартай албан бичгээр ХЗЯ-нд хүргүүлж, улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал", "Ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдах	90%	90%

							<p>хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын төслийг тус тус боловсруулж, холбогдох нэгжүүдээс санал авч ажиллаж байна. Сайдын 2024 оны А/202 дугаар тушаалаар батлагдсан Тэгш хамран сургах боловсролыг дэмжих, сургалт нөлөөллийн ажлын төлөвлөгөөнд 26 ажлыг тусган батлуулж, энэ хүрээнд ГСТ-г хэрэгжүүлэх арга зүйн сургалтад асрамж халамжийн төвийн багш нарт зориулан зохион байгуулав. Асрамж халамжийн төвд амьдарч буй хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн андан судалгаагаар 78 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асрамж халамжийн төвд амьдарч байгаа ч, 8 нь боловсролын үйлчилгээнд хамрагддаггүй байх ба төвийн багш нар нь ГСТ-г боловсруулах талаар ямар нэг мэдээлэлгүй байв.</p> <p>Хавсралт: 2 файл</p>		
3.3.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшихэд дэмжих төвийн загварыг	-	1. Дэмжих үйлчилгээ үзүүлж буй төвийн тоо, хамрагдсан хүүхдийн тоо 2. Тэгш хамран	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх аргачлал	1. Дэмжих үйлчилгээг туршин хэрэгжүүлэх тухай сайдын тушаал батлагдсан байна. 2.	1. Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий сургууль болон	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Туршилт зохион байгуулах тухай" А/60 дугаар тушаалаар 2023-2024 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын танхимын сургалтад хамрагдах боломжгүй	100%	100%

	<p>туршилтаар хэрэгжүүлэх, боловсролд тэгш хамруулах ажлыг удирдлага зохицуулалтаар хангана.</p>		<p>сургах чиглэлээр арга зүйг түгээн дэлгэрүүлсэн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн тоо</p>		<p>Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамран сургах сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлын удирдамжийг боловсруулж, сургагч багш нар бэлтгэгдсэн байна.</p>	<p>мэргэжлийн ТББ-ыг түшиглэн дэмжих үйлчилгээг хэрэгжүүлсэн байна. 2. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамран сургах сайн туршлагыг ерөнхий боловсролын 100 сургуульд түгээх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажилласан байна.</p>	<p>хөгжлийн бэрхшээлтэй 78 хүүхдэд тухайн түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт тохируулга хийж, ганцаарчилсан төлөвлөгөөний дагуу ганцаарчилсан сургалтыг туршилтаар зохион байгуулах арга хэмжээ авч, төр болон хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Ээлтэй ертөнц, Эрхэм нандин сувд, Энэрлийн түүчээ, Аутизмд хийсэн аялал ТББ-тай хамтран хэрэгжүүлэхээр холбогдох зардал /395,522.1₮/, бүртгэл, бусад зохицуулалтыг хийж, хэрэгжүүлэн ажилласан. Үүнд: Туршилт сургалтыг зохион байгуулах түшиц цэцэрлэг, сургуулийг сонгон 2024 оны 6 сар хүртэл үр дүнтэй зохион байгуулах, сургалтыг зохион байгуулах багш, багшийн туслахыг сонгон холбогдох сургалтад хамруулах, туршилт сургалтад хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг түшиц цэцэрлэг, сургуулийн бүртгэлд бүртгэх, туршилтын хугацаанд шаардагдах хувьсах зардал, хоолны мөнгийг тооцож олгох, шаардлагатай дэмжих үйлчилгээ үзүүлэх ажлыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд зохион байгуулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах зэрэг зохицуулалтыг хийсэн. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/60 дугаар</p>		
--	--	--	---	--	---	--	--	--	--



							<p>тушаалаар хэрэгжүүлсэн туршилтын үйл ажиллагааг Боловсролын сайдын 2024 оны “Туршилтын үйл ажиллагааг сунгах тухай” А/58 дугаар тушаалаар 2024-2025 оны хичээлийн жилд үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. /459,3 сая₮/ 2024 онд GPE, АХБ, Жайка, Японы ХИС-ийн төслийн хүрээнд 118 сургуульд ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах арга зүйг түгээн дэлгэрүүлж, 335 сургууль, цэцэрлэгийн удирдлагыг сургалтад хамруулж, Сайдын 2024 оны А/93 дугаар тушаалаар 2600 багшийг Тэгш хамран сургах боловсролын сургалтын хөтөлбөр, арга зүй, сургалтын орчинд тохируулга хийх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, суралцагчийг үнэлэх арга зүй” сэдэвт сургалтад хамруулсан.</p> <p>Хавсралт: 8 файл</p>		
3.3.5	Medle цахим сургуульд хэл засал, дохионы хэлний цахим хичээл оруулах ажлыг судлан, шийдвэрлэх, цахим	-	1. Бэлтгэсэн багшийн тоо 2. Хэл засал, дохионы хэлний цахим анги, суралцагчийн тоо	Дохионы хэл, хэл заслын чиглэлээрх цахим контент, цахим хичээлүүд	1. Хэл засал, дохионы хэлний цахим сургалт зохион байгуулах багшийг бэлтгэсэн байна. 2. Хүүхдэд	Хүүхдэд болон эцэг эхчүүдэд зориулсан хэл засал, дохионы хэлний цахим ангийг нээж, цахим сургалтыг	Хэл засал, дохионы хэлний цахим сургалт зохион байгуулах багш бэлтгэх 2 модуль сургалтын эхний сургалтад 218 багш бүртгүүлж, 23 мэргэжлийн багшийг сонгон сургалтад хамруулж, эдгээрийн 9 багш нь тэнцэн дараагийн шатны сургалтад хамрагдлаа. Medle Цахим сургуульд 2024 онд хэл	100%	100%

<p>контент, хэрэглэгдэхүү нээр хангах ажлыг зохицуулалта ар ханган ажиллана.</p>					<p>болон эцэг эхчүүдэд зориулсан хэл засал, дохионы хэлний цахим ангийг нээх бэлтгэл ажлыг зохицуулалта ар хангаж ажилласан байна.</p>	<p>эхлүүлсэн байна.</p>	<p>засал, дохионы хэлний I, II түвшний тус бүр 2 анги, эцэг эхчүүдэд зориулсан 1 анги, нийт 5 анги нээхээр төлөвлөж, бэлтгэл ханган ажилласан. 2024 оны 5дугаар сарын 21-ний өдөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэд төрийн үйлчилгээг тохируулгатайгаар авах ихүртээмж, дохионы хэлний handpro апп-ний нээлтийг зохион байгуулж, БШУ-ны сайд болон бусад 300 төлөөлөгчид оролцов. Мөн medlee цахим сургуульд хэл засал, дохионы хэлний анги нээх бэлтгэлийг хангаж, ирэх хичээлийн жилээс элсэлтээ авч, сургалтаа зохион байгуулах бэлтгэл хангав. Мэдлэ цахим сургуулийн дохио, хэл заслын цахим ангид элсүүлэх суралцагчдыг сонгох зорилгоор багш, эцэг эх, асран хамгаалагч, хүүхдээс авах 3 төрлийн асуулгыг эцэслэн боловсруулж, google forum-аар бэлтгэн аймаг, нийслэлийн боловсролын газруудаар дамжуулан асуулга авахаар БЯ-ны 2/2263 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Хүүхдээс авах асуулга: <a href="https://forms.gle/Xg1DP1sTEZDGasYs5">https://forms.gle/Xg1DP1sTEZDGasYs5</a> Багшаас авах асуулга: <a href="https://forms.gle/3Vauvn6zgijAfCAF8">https://forms.gle/3Vauvn6zgijAfCAF8</a> Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс авах асуулга: <a href="https://forms.gle/jpe32XuM7tWJW">https://forms.gle/jpe32XuM7tWJW</a></p>		
--	--	--	--	--	--	-------------------------	---	--	--

							Y8T7 Хавсралт: 4 файл		
3.3.6	Явуулын багшийн сургалтын жишиг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтын модуль боловсруулж, сургалт зохион байгуулах ажлыг удирдлага зохицуулалтаар хангах	20,0	Арга зүйн модуль /4 хөтөлбөрөөр/ Сургалтад хамрагдсан багшийн тоо	Боловсрол, шинжлэх ухааны 2023 оны А/158 дугаар тушаал	Явуулын багшийн сургалтын жишиг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтын 4 модуль боловсруулагдсан байна.	ЕБС-ийн бага ангийн болон насан туршийн боловсролын багш нарыг сургалтад хамруулсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны 2023 оны А/158 дугаар тушаалаар батлагдсан явуулын багшийн сургалтын жишиг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтын модуль боловсруулах ажлыг БСҮХ-тэй хамтран гүйцэтгэв. Сургалтын модуль боловсруулах 7,5 мянган долларын санхүүжилтийг НҮБХС-аас шийдвэрлэсэн. Эрүүл мэндийн улмаас танхимын сургалтад хамрагдах боломжгүй хүүхдийн "Математик", "Монгол хэл", "Нийгэм ахуйн баримжаа", "Дүрслэх урлаг, технологи"-ийн сургалтын моудлийг боловсруулж, арга зүйн сургалтыг 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулав. Тус сургалтад ебс, насан туршийн суралцахуйн багш нар нийт 45 хүн хамрагдаж, танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй хөгжлин бэрхшээлтэй хүүхэд дээрх хичээлээр сургалт зохион байгуулах арга зүйд суралцав. Боловсролын сайдын 2024 оны А/202 дугаар тушаалаар батлагдсан "Тэгш хамран сургах боловсролыг дэмжих, сургалт нөлөөллийн ажлын төлөвлөгөө"-нд 26 ажлыг тусган батлуулсан	100%	100%

						<p>ба тус төлөвлөгөөний тус төлөвлөгөөний 10-т Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйг түгээх ажлыг тусгаж энэ хүрээнд дээрх сургалтыг зохион байгуулж, Боловсролын яамны сайтаар олон нийтэд мөн мэдээлэл түгээж ажиллав. Түүнчлэн ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тохируулга хийх замаар ялгаатай хэрэгцээтэй суралцагчийг хөгжих, суралцах тэгш боломжоор хангах нь зайлшгүй тулгамдсан асуудал тул ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн судлагдахууны багш нарыг ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад тэгш хамран сургах боловсролын сургалтын хөтөлбөр, арга зүй, сургалтын орчинд тохируулга хийх онол, арга зүйн сургалтад 2600 багшийг хамруулсан. ЕБС-ийн 1-12 ангийн сурах бичиг, аудио материалыг Боловсролын мэдээллийн технологийн төвтэй хамтран medle.mn кодыг сурах бичиг бүрд байршуулж, харааны бэрхшээлтэй болон унших чадварын алдагдалтай хүүхдэд хэрэглэх боломжийг олгож байна.</p> <p>Хавсралт: 4 файл</p>	
--	--	--	--	--	--	--	--

3.3. 7	Бага боловсролын казак, тува хэлний сургалтын хөтөлбөр боловсруулах ажлыг удирдлага, зохицуулалта ар хангах	-	Бага боловсролын казах, тува хэлний сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан байна.	-	Бага боловсролын казах, тува хэлний сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн төслийг боловсруулсан байна.	Бага боловсролын казах, тува хэлний сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан байна.	Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал 2024-2036"-ийг үндэслэн бага боловсролын тува хэлний сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Энэхүү сургалтын хөтөлбөрт тува хэлний судлагдахуунаар сурагчийн эзэмших ерөнхий болон суурь чадамж, тува хэлний чадвар (сонсох, ярих, унших, бичих)-ууд, агуулгын залгамж холбоо (ай, дэд ай), тува хэлний сургалтын арга зүй, орчин хэрэглэгдэхүүн, үнэлгээ, суралцахуйн удирдамж гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал болон багшлахуй, суралцахуйн онол, зарчимд нийцүүлэн тодорхойлов. Энэ удаа багш нартаа бага боловсролын тува хэлний шинэчилсэн сургалтын хөтөлбөр, дасгал ажлын дэвтэрийг Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын 2дугаар сургуульд, Казах хэлний сургалтын хөтөлбөр, гарын авлага, дасгал ажлын дэвтрийг Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ЕБ-ын 4 дүгээр сургуульд, Сагсай сумын ЕБ-ын 1 дүгээр сургуульд тус тус	100%	100%
-----------	---	---	---	---	--	---	---	------	------

							туршиж байна. Хавсралт: 2 файл		
3.3.8	Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий сургуулийн менежментийг сайжруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах	-	Авч хэрэгжүүлсэн аргын хэмжээний тоо	БШУС-ын 2023 оны А/467 дугаар тушаал	Төлөвлөгөөнд туссан ажлын гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна.	Төлөвлөгөөнд туссан ажлын гүйцэтгэл 90 хувьд хүрсэн байна.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны Төлөвлөгөө батлах тухай А/467 дугаар тушаалаар боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд 2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн. 2024 онд Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах, хөгжих тохируулгат орчныг бүрдүүлэх, боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, чадамжийн гэрчилгээтэй төгсгөх асуудлыг судалж, Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын ерөнхий газартай хамтран 28 цагийн агуулгатай “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах” арга зүйн сургалтыг зохион байгуулж, сургалтад 55, 63 дугаар сургуулийн 14 багшийг хамруулж, нэгж хөтөлбөрийн боловсруулалтыг сайжруулахад нь арга зүйн зөвлөмж өгч	100%	100%

						<p>чиглүүлсэн. Үүний үр дүнд 55р сургууль талх нарийн боовчин, зочид буудлыг үйлчлэгч, бариста, цэцэрлэгжүүлэгчийн мэргэжлийн сургалт зохион байгуулж эхэлсэн. Менежментийг сайжруулах хүрээнд 63, 70 дугаар сургуулийн хамтын ажиллагааны төлөвлөгөөнд сургалтын менежерүүдийг 2023-2024 оны хичээлийн жилийн 3-р улиралд сэлгэн ажиллуулсан. Нийслэлийн ЗД-д албан бичиг хүргүүлж, ерөнхий боловсролын 70-р сургуулийн дээвэр засварт 518.0 сая, 29р сургуулийн бүрэн засварт 4,8тэрбум төг-ийг нийслэлийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэсэн. Улсын төсвөөр 116-р сургуульд, Өвсний үндэс төсөлд хүсэлт илгээж, 55-р сургуулийн лифтийг шийдүүлсэн. 29 дүгээр сургуульд ширээ, сандал авах 130.0 сая төг, тусгай 6 сургуульд 800,0сая төгрөгийн сургалтын тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, 55, 63, 70 дугаар сургуульд автобусыг тус тус шийдвэрлэж, ажилласан.</p>		
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ								
4.1.	Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг	-	-	-	-	Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд	100%	100%

	боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах						сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах зорилтыг бүрэн хангаж ажилласан.		
4.1.1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах.	-	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо	2023 оны биелэлтийн хувь	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг хариуцсан чиг үүргийн дагуу холбогдох заалтуудын хэрэгжилтийг бүрэн хангуулж, биелэлтийг хугацаанд нь тайлагнасан.	100%	100%
4.1.2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах	-	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилт хангагдсан байна.	Хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилт хангагдсан байна.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хариуцсан чиг үүргийн дагуу холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг хугацаанд нь тайлагнасан.	100%	100%
4.1.3	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг	-	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2022 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангуулж, биелэлтийг хугацаанд нь тайлагнасан.	100%	100%



	тайлагнах.								
4.1.4	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	-	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг т нэгжийн чиг үүрэгт туссан чиглэлээр хэрэгжилтийг <a href="https://meds.igovernment.mn/law/">https://meds.igovernment.mn/law/</a> системд тайлагнасан.	100%	100%
4.1.5	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	-	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь	2023 оны байршсан мэдээлэл	1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. 2. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулсан байна.	1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. 2. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулсан байна.	Тэгш хамран сургах боловсролыг сурталчлах, арга зүйг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор тэгш хамран сургах боловсролын бодлого, хэрэгжилт, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл, хэлтсийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тухай бүр олон нийтэд мэдээлж, ажилласан. Мөн олон нийтэд чиглэсэн нөлөөллийн 35 контентийг АХБ, Жайка, Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл, Японы ХИС-тай хамтран бэлтгэж, яамны болон БЕГ-ын сайтаар дамжуулан олон нийтэд түгээсэн. Түүнчлэн Боловсролын сайдын 2024 оны А/202 дугаартай тушаалаар батлагдсан Тэгш хамран сургах боловсролыг дэмжих сургалт, нөлөөллийн үйл ажиллагааны	100%	100%

							төлөвлөгөөний дагуу хийж хэрэгжүүлсэн ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод сурталчлан таниулсан. Хавсралт: 10 файл		
--	--	--	--	--	--	--	--	--	--

Үнэлсэн:

.....

.....

(албан тушаал )

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)

Тайлагнасан:

.....

.....

(албан тушаал )

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)